

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ын 2.3 дахь хэсгийн “... үл хөдлөх хөрөнгө,” гэсний дараа “хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл,” гэж нэмсүгэй.

2.Мөн журмын 1.1 дэх хэсгийн “Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай” гэснийг “Төрийн болон албаны нууцын тухай,” гэж, 2.6, 2.7 дахь хэсгийн “... халхавч” гэснийг “зохиомол” гэж, 3.1 дэх хэсгийн “... нэгж” гэснийг “тусгай алба” гэж тус тус өөрчилсүгэй.

3.Мөн журмын 2.3 дахь хэсгийн “... гэрч, хохирогчид” гэснийг хассугай.

4.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт үүрэг тус тус болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

САЙД

Х.НЯМБААТАР

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг тусгай техник, хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”-ын 1.1, 3.1, 3.10 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/“1.1.Энэ журмаар гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгсэл /цаашид “тусгай техник хэрэгсэл” гэх/-ээр хангах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.”.

2/“3.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.5-д заасан хамгаалалтанд авах тухай прокурор, шүүгчийн шийдвэрийг хүлээн авсан албан тушаалтан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу судалж, удирдлагадаа бичгээр танилцуулна.”.

3/“3.10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.2-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлэл үүсэж болзошгүй нөхцөл байдал тогтоогдвол энэ журамд заасан тусгай техник, хэрэгсэлийн аль тохирохыг сонгох, шаардлагатай тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг хамтатган нэн даруй хэрэгжүүлнэ.”.

2.Мөн журмын 1.2 дахь хэсгийн “Мөрдөх алба болон” гэснийг, 3.11 дэх хэсгийн “Хамгаалалтанд авсан тухайгаа” гэснийг, 3.12 дахь хэсгийн “мөрдөгч,” гэснийг тус тус хассугай.

3.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

САЙД

Х.НЯМБААТАР

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулагатай хэсэг нэмсүгэй.

1/“3.7.Насанд хүрээгүй хамгаалуулагчийн хувьд түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй энэ журмын 3.3-д заасан гэрээг байгуулна.”.

2.Мөн журмын 1.1, 1.4 дэх хэсгийг дор дурдснаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/“1.1.Энэхүү журмын зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан иргэдийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлага, аюул заналхийллээс хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалт /цаашид "Хамгаалалт" гэх/-д авах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”;

2/“1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан байгууллагын хамгаалалтын ажилтан /цаашид "Хамгаалагч" гэх/ нь мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан иргэд /цаашид "Хамгаалуулагч этгээд" гэх/-ийн аюулгүй байдлыг хангахаар тусгайлан томилогдсон хамгаалалтын ажлын зохих түвшний мэдлэг, дадлага, туршлагатай, галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүй тулалдах мэхийг эзэмшсэн байвал зохино.”.

3. Мөн журмын 1.2 дахь хэсгийн “Авилгын эсрэг хууль, Төрийн нууцын тухай хууль” гэснийг “Авлигын эсрэг хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль” гэж өөрчилсүгэй.

4. Мөн журмын 1.2 дахь хэсгийн “Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай,” гэснийг хассугай.

5.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт тус тус үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

САЙД

Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Гэрээ, маягтын загвар батлах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.10 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангахад хамтран ажиллах гэрээ”-ний загварыг нэгдүгээр, “Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээний гэрээ”-ний загварыг хоёрдугаар, “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулахад хамтран ажиллах гэрээ”-ний загварыг гуравдугаар, “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтад авах гэрээ”-ний загварыг дөрөвдүгээр, “Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний гэрээ”-ний загварыг тавдугаар, “Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн тухай тэмдэглэл /маягт 1/, Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх /өөрчлөх/ тухай санал /маягт 2/, Хамгаалалтын арга хэмжээг цуцлах тухай санал /маягт 3/, Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах тухай санал /маягт 4/, Баталгаа /маягт 5/”-ыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалаар батлагдсан гэрээ, маягтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2015 оны А/88 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД

Х.НЯМБААТАР

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

.....
.....
.....

.....
.....
.....

/эрх бүхий байгууллагын албан тушаалтан/

/төрийн болон төрийн бус байгууллага/

Огноо:

Огноо:

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ
ХАНГАХАД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

20... оны ... сарын ... өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас _____ /цаашид “хамгаалагч тал” гэх/ нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____ /цаашид “хамтран хэрэгжүүлэгч” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх\ Монгол Улсын Иргэний хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 6, 11, 23, 25 дугаар зүйл, Хууль зүйн Сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”, _____ дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч _____-ны

/аль тохирохыг доогуур зурах/ 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар тогтоол, захирамжийг тус тус үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
/аль тохирохыг доогуур зурах/

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан мэдээллийн нууцлалыг хангах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан этгээд /цаашид “хамгаалуулагч” гэх/-ийн амь бие, эрүүл мэнд, мэдээллийн аюулгүй байдлыг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсоох чиглэлээр хамтран ажиллахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйл, Хууль зүйн Сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ын Хоёрдугаар зүйлийн 2.4, 2.5, 2.6 дахь хэсэгт заасан хэлбэрээр хамгаалуулагчийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, хамгаална.

1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хамгаалуулагчийн мэдээллийг бүхэлд нь болон хэсэгчилсэн байдлаар мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авч болно.

1.5.Талууд хамгаалуулагч болон хамгаалагч талын хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай техник, программ хангамжийг бүрэн хангана.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1.Хамгаалагч нь дараах эрхтэй :, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагчийн болон хамгаалалтын арга хэмжээний мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран хэрэгжүүлэгч талд хууль ёсны шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

2.1.2.хамгаалуулагч болон хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг гаргуулан авах;

2.2.Хамгаалагч нь дараах үүрэгтэй:

2.2.1.эрх бүхий албан тушаалтны шийдвэрт нэмэлт, өөрчлөлт орсон, цуцлагдсан тохиолдолд хамтран хэрэгжүүлэгч талд даруй хүргүүлэх;

2.2.2.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах.

2.3.Хамтран хэрэгжүүлэгч нь дараах эрхтэй: үүрэгтэй:

2.3.1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар нэмэлт тодруулга хийх;

2.4.Хамтран хэрэгжүүлэгч нь дараах үүрэгтэй:

2.4.1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээж авсан байгууллага нь шийдвэрт дурдсан хамгаалуулагч иргэний мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу нууцлах, задруулахгүй байх, баталгаа гаргах;

2.4.2.хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилт, хамгаалуулагчийн мэдээллийг авахаар сан мэдээллийн баазад нэвтрэх оролдлого хийсэн этгээдийн талаарх мэдээллийг хамгаалагч талд даруй мэдэгдэх, мэдээлэх;

2.4.3.програм хангамжид техникийн саатал үүссэн тохиолдолд хамгаалагч талд даруй мэдэгдэх.

Гурав.Хориглох зүйл

3.1.Талууд дараах нөхцөл байдлыг үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

3.1.1.шийдвэрийг хэрэгжүүлэхдээ хугацаа алдах;

3.1.2.хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой мэдээллийг бусдад дамжуулах, нийтлэх, мэдээлэх;

3.1.3.хувийн харилцаа тогтоох.

Дөрөв.Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

4.1.Энэхүү гэрээг хамтран хэрэгжүүлэгч байгууллага шийдвэрийг хүлээж авсан өдрөөс буюу 20 оны дугаар сарын-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3-т заасан үндэслэлээр хамгаалалтыг цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

4.2.Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2-т заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Тав.Маргаан шийдвэрлэх

5.1.Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа.Бусад нөхцөл

8.1.Энэхүү гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.

8.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.

8.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:
төлөөлж:

Хамгаалуулагч талыг

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ
БОЛОН ТУСГАЙ ТЕХНИК, ХЭРЭГСЛЭЭР ХАНГАХ ХАМГААЛАЛТЫН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭ

20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр № Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас _____ /цаашид
“хамгаалагч тал” гэх/ нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____
овогт _____-ын _____ /цаашид “хамгаалуулагч” гэх/ нар Монгол
Улсын иргэний хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай
хуулийн 5, 7, 12, 20-23 дугаар зүйл, Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12 дугаар зүйл, Хууль
зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг тусгай техник,
хэрэгслээр хангах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”,
_____ дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч _____-ны

/аль тохирохыг доогуур зурах/

20..... оны сарын-ны өдрийн дугаар тогтоол, захирамжийг тус тус үндэслэн харилцан
/аль тохирохыг доогуур зурах/
тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хэрэгжүүлэх, хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд хуульд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3.Хамгаалуулагч нь “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслээр хангах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ын хоёрдугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан тусгай техник, хамгаалах хэрэгслээр хангагдах бөгөөд тусгай техник, хэрэгслийг дангаар болон хамтатган хэрэглэх шийдвэрийг хамгаалагч тал шийдвэрлэнэ.

1.4.Хамгаалагч тал шаардлагатай тохиолдолд гэрээт харуул, хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллаж болно.

1.5.Гэрээт харуул, хамгаалалтын байгууллага нь Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг тусгай техник, хэрэгслээр хангах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд уг журамд заасан үүргийг /дохиолол хамгаалалтын төхөөрөмж, галын аюулын дохиолол, дүрсний хяналтын болон байршил тогтоох хэрэгсэл, хаалганы цахим болон хурууны хээ мэдрэгч цоож ашиглах/ гүйцэтгүүлнэ.

Хоёр.Хамгаалагч талын эрх, үүрэг

2.1.Хамгаалагч нь дараахь эрх, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээ, мэдээллийг цуглуулах, хамгаалуулагчаас гаргуулан авах;

- 2.1.2.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс хууль, журам, дүрэм, бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг дагаж мөрдөх болон бусад тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;
- 2.1.3.хамгаалуулагчид нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник, харилцаа холбооны хэрэгслийг хэрэглэх, ашиглах талаар зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах;
- 2.1.4.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хамгаалуулагчийн ажлын болон орон байр, автомашин гадны халдлага, довтолгоонд өртсөн, өртөж болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд ажлын болон орон байр, автомашинд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх техник тоног төхөөрөмж суурилуулах;
- 2.1.5.хамгаалуулагчийн гэр орон, ажлын байранд нэвтэрч хамгаалуулагчийн хэрэглэж буй тусгай хэрэгсэл, техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийх, шаардлагатай бол солих.
- 2.2.Хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцана.
- 2.3.Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй тохиолдолд гэмт хэргийн шинжтэй бол мөрдөгчид нэн дариу мэдэгдэж, шалгуулах, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан “Урьдчилан сануулах” аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар мөрдөгчид санал хүргүүлнэ.
- 2.4.Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслийг шаардлагатай үед хэрэглэхээс бусад тохиолдолд зориулалтын бусаар ашиглах, оролдох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан талаараа хамгаалагч талд мэдэгдээгүйн улмаас шаардлагатай үед хэрэглэхэд ажиллахгүй болсон хамгаалуулагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хор хохирлыг хамгаалагч тал хариуцахгүй.

Гурав.Хамгаалуулагчийн эрх, үүрэг

- 3.1.Хамгаалуулагч нь дараахь эрх, үүрэгтэй:
- 3.1.1.хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;
- 3.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан туслалцааг авах;
- 3.1.3.хамгаалагч тал эрх, үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих;
- 3.1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу сэтгэл зүйн туслалцаа авах;
- 3.1.5.Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, хамгаалагч талаас өгсөн тусгай техник, хэрэгслийг ашиглах, хадгалах, бүрэн бүтэн байдлыг хангах, аюулгүй байдлаа хамгаалах талаарх зааварчилгаа, зөвлөмж, гэрээтэй танилцаж, биелүүлэх;
- 3.1.6.хамгаалагч талд гэр бүл, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, найз нөхдийн талаарх мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
- 3.1.7.Хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;
- 3.1.8.хамгаалагч талаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 3.1.9.тусгай техник, хэрэгслийг үрэгдүүлсэн, ямар нэгэн гэмтэл, эвдрэл үүссэн тохиолдолд оролдохгүй байж хамгаалагч талд нэн даруй мэдэгдэх;
- 3.1.10.хамгаалуулагч нь хувийн хамгаалалтын хэрэгслийг биедээ авч явах эрхтэй бөгөөд хуульд заасан үндэслэл журам, хамгаалагч талаас өгсөн зааварчилгааны дагуу хэрэглэнэ. Хэрэглэсэн тухайгаа хамгаалагч талд бичгээр даруй мэдэгдэх;
- 3.1.11.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг чандлан сахих, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах.
- 3.2.Хамгаалуулагч нь тусгай техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажиллах хэвийн горимыг алдагдуулахгүй байж, өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тусгай техник, хэрэгслийг эвдэлсэн, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн төлнө.

Дөрөв.Хориглох зүйл

- 4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- 4.1.1.хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг бусдад дамжуулах, задруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх;
 - 4.1.2.тусгай техник, хэрэгслийг бусдад дамжуулах, барьцаанд тавих, худалдах, шаардлагатайгаас бусад тохиолдолд оролдох, эд ангийг салгах;
 - 4.1.3.хамгаалагч талаас тавьж олгосноос өөр тусгай хэрэгсэл ашиглах;
 - 4.1.4.тусгай техник, хэрэгслийг зориулалтын бусаар хэрэглэх;
 - 4.1.5.хамгаалалтын арга хэмжээ үргэлжлэх хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх;
 - 4.1.6.талууд хувийн харилцаа тогтоох.

Тав.Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

- 5.1.Гэрээ 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3-т заасан үндэслэлээр хамгаалалтыг цуцлах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2.Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2-т заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.
- 5.3.Шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тодорхой хугацаагаар сунгаж болно. Энэ хугацаа нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үндэслэлээр хамгаалалтын арга хэмжээг цуцалсан хугацаанаас хэтрэхгүй байна.

Зургаа.Маргаан шийдвэрлэх

- 6.1.Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо.Гэрээний хавсралт

- 7.1.Нэг бүрийн тусгай хэрэгсэл, тусгай техник хэрэгслийг ашиглах талаар хамгаалуулагчид өгсөн зааварчилгаа нь энэхүү гэрээний хавсралт байна. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм.Бусад

- 8.1.Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.
- 8.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.
- 8.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:

Хамгаалуулагч талыг төлөөлж:

Хаяг:
Утас:
Факс:
Цахим хаяг:

Хаяг:
Утас:
Факс:
Цахим хаяг:

Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээний гэрээний хавсралт

НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ ЗААВАРЧЛАГА

20... оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

_____ би 20... оны ... сарын ... өдөр байгуулсан ... тоот гэрээний дагуу эрүүгийн _____ дугаар хэргийн гэрч /хохирогч, ГХХТХ-ийн 5.4-т заасан иргэн/ _____ овогт _____-ны _____-д нэг бүрийн тусгай хэрэгсэл болох цахилгаан бороохой /нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч/ ашиглах талаарх зааварчлагыг 20... оны ... сарын ...-ны өдрийн ... цаг ... минутад өгөв. Үүнд:

1.Нэг бүрийн тусгай хэрэгслийг ашиглах

- 1.1.Тусгай хэрэгслийг бусдад шилжүүлэхгүй, мэдэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хэрэглэхэд хялбар газар авч явна.
- 1.2.Тусгай хэрэгслийг хадгалахдаа /гэр орон/ хүүхэд болон бусад гэр бүлийн гишүүд оролдох, хүрэх боломжгүй нөхцөлийг бүрдүүлж, өөрт нь аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй тохиолдолд хэрэглэнэ.
- 1.3.Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд халдсан идэвхтэй үйлдэл бүхий нөхцөл байдал илэрсэн тохиолдолд халдагч /заналхийлэгч/ этгээдийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор олгогдсон тусгай хэрэгслээс аль тохирохыг сонгож хэрэглэнэ. /заналхийлэгч этгээдийн довтолгоо зогссон тохиолдолд үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглох, аль болох зугтаах, хамгаалагч талд даруй мэдэгдэх/
- 1.4.Санамсар, болгоомжгүйгээр нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн цацах товч дарагдсан, гартаа хүргэсэн тохиолдолд нүдэндээ гараа хүргэхгүй байх, нүдэнд хүрсэн тохиолдолд яаралтай хүйтэн усаар угаах, өрөө, тасалгаанд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг цацсан тохиолдолд цонх, салхивчийг онгойлгож агааржуулах.

2. Хориглох зүйлс

- 2.1.Тусгай хэрэгслийг жирэмсэн болон бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй нь илт мэдэгдэж байгаа, насанд хүрээгүй болох нь тодорхой мэдэгдэж байгаа этгээдэд хэрэглэх;
- 2.2.Цахилгаан бороохойг нүүр болон биеийн ил хэсэгт, нэг байрлалд 5 секундээс илүү хугацаагаар хэрэглэх;
- 2.3.Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг 1 метрээс хол зайд хэрэглэх, салхины өөдөөс цацах, албан тасалгаанд хэрэглэх;
- 2.4.Халдагч этгээд /заналхийлэгч/-ийн идэвхгүй болон үг хэлээр доромжилсон үйлдлийн эсрэг олгогдсон нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх;
- 2.5.Хамгаалуулагч нь аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын нөхцөлөөс бусад байдалд тусгай хэрэгслийг хэрэглэх.

3.Хүлээх хариуцлага

- 3.1.Зааварчилгааны 2.5-д заасан заалтыг хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН:

_____ албан тушаалтай
 _____ цолтой / /

ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦСАН:

_____ / /

Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээний гэрээний хавсралт

ТУСГАЙ ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХ ЗААВАРЧЛАГА

20... оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

_____ би 20... оны ... сарын ... өдөр байгуулсан ... дугаартай гэрээний дагуу эрүүгийн _____ дугаар хэргийн гэрч /хохирогч, ГХХТХ-ийн 5.4-т заасан иргэн/ _____ овогт _____-ны _____-д

_____ тусгай техник, хэрэгслийг ашиглах талаарх зааварчлагыг 20... оны ... сарын ...-ны өдрийн ... цаг ... минутад өгөв.

1.Тусгай техник, хэрэгслийг ашиглах

- 1.1.Тусгай техник хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж, байрлуулсан газрыг өөрчлөхгүй байх, байнгын ажиллагааны горимд /асаалттай, цэнэгтэй/ байлгах;
- 1.2.Тусгай техник, хэрэгслийн ажиллагааны горим алдагдсан, ажиллагаагүй болсон, бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдолд хамгаалагч талд нэн даруй мэдэгдэх, шийдвэрлүүлэх;
- 1.3.Аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй тохиолдолд тусгай техник, хэрэгсэл /байршил тогтоогч/-ийн “SOS” товч дээр чичирэх хөдөлгөөн мэдрэгдэх хүртэл хугацаанд дарах. /Дарснаар удирдлагын төв болон хамгаалалтын ажилтанд таны байгаа газар, ойр болж байгаа зүйлсийн, ярианы талаарх дуу чимээний мэдээлэл очно/

2. Хориглох зүйлс

- 2.1.Тусгай техник, хэрэгслийг салгах, оролдох, норгох зэрэг үйлдэл хийх;
- 2.2.Хамгаалалтын арга хэмжээ болон тусгай техник, хэрэгслийн талаарх мэдээллийг бусдад задруулах;
- 2.3.Шаардлагагүй тохиолдолд “SOS” товч, бусад товчийг дарах;
- 2.4.Суурилуулсан тусгай техник, хэрэгслийн байршил, харах өнцгийг өөрчлөх.

3. Хүлээх хариуцлага

3.1.Хамгаалуулагчийн үүргээ биелүүлээгүй /тусгай техник, хэрэгслийг асаах, цэнэглэх, хамгаалуулагчийн буруутай үйлдлээс төхөөрөмжийн ажиллагааны горим алдагдсан, ажиллагаагүй болсон, энэ талаар мэдсээр байж хамгаалагч талд мэдэгдэхгүй/-гээс тухайн нөхцөл байдалд хамгаалуулагчид эрсдэл, хохирол учирвал хамгаалагч тал хариуцахгүй.

ЗААВАРЧЛАГА ӨГСӨН:

_____ албан тушаалтай
_____ цолтой / /

ЗААВАРЧЛАГАТАЙ ТАНИЛЦСАН:

_____ / /

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

.....
.....
.....

.....
.....
.....

/эрх бүхий байгууллагын албан тушаалтан/

/төрийн болон төрийн бус байгууллага/

Огноо:

Огноо:

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ АЮУЛГҮЙ ГАЗАРТ
ТҮР БАЙРЛУУЛАХАД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20... оны ... сарын ... өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас _____ /цаашид
“хамгаалагч тал” гэх/ нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____

_____ /цаашид “хамтран хэрэгжүүлэгч” гэх/ нар /цаашид
хамтад нь “Талууд” гэх\ Монгол Улсын Иргэний хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хувь
хүний нууцын тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 6, 13, 18, 23, 25 дугаар
зүйл, Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар
баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын
арга хэмжээг хэрэгжүүлэх журам”, _____ дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн анхан

/аль тохирохыг доогуур зурах/

шатны шүүхийн шүүгч _____-ны 20... оны ... сарын ...-ны өдрийн
дугаар тогтоол, захирамжийг тус тус үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

/аль тохирохыг доогуур зурах/

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан аюулгүй газарт түр
байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан этгээд
/цаашид “хамгаалуулагч” гэх/-ийн амь бие, эрүүл мэнд, сэтгэл санааг гадны халдлагаас
урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсоох, хамгаалах байрыг хангах, ашиглах чиглэлээр
хамтран ажиллахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчмыг
баримтална.

1.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл, Хууль зүй, дотоод хэргийн
сайдын баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын
хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэн хамгаалуулагчийг хамгаалах
байранд байрлуулж аюулгүй байдлыг ханган хамгаална.

1.4.Талууд хамгаалуулагч болон хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой мэдээллийг
гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

Хоёр.Хамгаалагчийн эрх, үүрэг

2.1.Хамгаалагч нь дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагчийн болон хамгаалалтын арга хэмжээний мэдээлэл задрахаас урьдчилан
сэргийлэх зорилгоор хамтран хэрэгжүүлэгч талд хууль ёсны шаардлага тавих, баталгаа
гаргуулан авах;

- 2.1.2.хамгаалуулагч болон хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг гаргуулан авах;
- 2.1.3.эрх бүхий албан тушаалтны шийдвэрт нэмэлт, өөрчлөлт орсон, цуцлагдсан тохиолдолд хамтран хэрэгжүүлэгч талд даруй хүргүүлэх;
- 2.1.4.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах;
- 2.1.5.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хамгаалах байр, хамгаалуулагчийн орон байр, автомашин гадны халдлага, довтолгоонд өртсөн, өртөж болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд хамгаалах байранд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх техник тоног төхөөрөмж суурилуулах.

Гурав.Хамгаалах байрны эрх, үүрэг

3.1.Хамтран хэрэгжүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй:

- 3.1.1.эрх бүхий албан тушаалтны шийдвэр, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар нэмэлт тодруулга хийх;
- 3.1.2.хамгаалуулагч иргэний мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу нууцлах, задруулахгүй байх, баталгаа гаргах;
- 3.1.3.хамгаалагч талаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 3.1.3.хамгаалах байранд гарсан хамгаалуулагчтай холбоотой асуудлыг хамгаалагч талд даруй мэдэгдэх;
- 3.1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан туслалцааг хамгаалуулагчид үзүүлэх авах.

Дөрөв.Хориглох зүйл

- 4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 4.1.1.талууд хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг бусдад дамжуулах, задруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх;
 - 4.1.3.хамгаалах байранд хууль, журамд заасан хориглосон үйл ажиллагаа явуулах;
 - 4.1.4.хувийн харилцаа тогтоох.

Тав.Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

- 4.1.Энэхүү гэрээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3-т заасан үндэслэлээр хамгаалалтыг цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.
- 4.2.Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2-т заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зургаа.Маргаан шийдвэрлэх

- 6.1.Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо.Бусад нөхцөл

- 7.1.Энэхүү гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.
- 7.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ;
- 7.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАМГААЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

ХАМГААЛАХ БАЙРЫГ ТӨЛӨӨЛЖ:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оныдугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ АЮУЛГҮЙ ГАЗАРТ ТҮР
БАЙРЛУУЛАХ ХАМГААЛАЛТАД АВАХ ГЭРЭЭ

20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр № _____ хот, аймаг

Энэхүү гэрээг нэг талаас _____ /цаашид
“хамгаалагч тал” гэх/ нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____ овогт
_____ -ын _____ /цаашид “хамгаалуулагч” гэх/ нар Монгол Улсын Иргэний
хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 6, 13, 17,
18, 20-24 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй
газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”,
_____ дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн

/аль тохирохыг доогуур зурах/

анхан шатны шүүхийн шүүгч _____ -ны 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар
тогтоол, захирамжийг тус тус үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

/аль тохирохыг доогуур зурах/

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3.Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу хамгаалуулагчийг хамгаалах байранд байрлуулж хамгаална.

1.4.Хамгаалуулагчийн зөвшөөрснөөр хамгаалалтын ажиллагаанд түүний орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, харилцаа холбоог ашиглаж болно.

1.5.Хамгаалуулагч нь гэр орон /аюулгүй газар/ болон хамгаалах байрнаас урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн гараснаас гадны халдлага, довтолгоонд өртсөн тохиолдолд хамгаалагч тал хариуцахгүй.

Хоёр.Хамгаалагчийн эрх, үүрэг

2.1.Хамгаалагч нь дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.Монгол Улсын хууль, дүрэм, журам, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг биелүүлэхийг хамгаалуулагчаас шаардах;

2.1.2.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээ, мэдээллийг цуглуулах, гаргуулан авах;

2.1.3.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

2.1.4.хамгаалуулагчаас уулзах иргэд, оролцох арга хэмжээ, бусад нөхцөл байдлыг тусгасан мэдээллийг урьдчилж авах;

2.1.5.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд учрах эрсдэл бүхий шинэ нөхцөл байдал, бусад нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хамгаалах байрыг солих;

2.1.6.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, хамгаалах байр, хамгаалуулагчийн орон байр, автомашин гадны халдлага, довтолгоонд өртсөн, өртөж болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд орон байр, автомашинд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх техник тоног төхөөрөмж суурилуулах;

2.1.7.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах;

2.1.8.хамгаалуулагчийг хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээллээр хангах.

Гурав.Хамгаалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хамгаалуулагч нь дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;

3.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан туслалцааг авах;

3.1.3.хамгаалагч талд эрх, үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих;

3.1.4.Монгол Улсын хууль, журам, дүрэм, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг, хамгаалагч талаас өгсөн заавар, зөвлөмжтэй танилцаж, биелүүлэх;

3.1.5.хамгаалагч талд гэр бүл¹, гэр бүлийн гишүүн², төрөл³, садангийн⁴ хүн, найз нөхдийн талаарх мэдээллийг саадгүй гаргаж өгөх;

3.1.6.хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;

3.1.7.хамгаалагч талаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

3.1.8.гэр орон /аюулгүй газарт/ болон хамгаалах байрнаас урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн гарахгүй байх;

3.1.9.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хамгаалах, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах;

3.1.10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу туслалцаа авах.

Дөрөв.Хориглох зүйл

4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1.хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг бусдад дамжуулах, задруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх;

4.1.2.хамгаалалтын арга хэмжээний үеэр согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх;

4.1.3.үзвэр, үйлчилгээ, олон нийтийн газар /зах, баар/ зорчих,олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох;

4.1.4.хувийн харилцаа тогтоох.

Тав.Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

5.1.Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үндэслэлээр хамгаалалтыг цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2.Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2-т заасныг

¹ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт зааснаар;

² Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4 дэх хэсэгт зааснаар;

³ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.5 дахь хэсэгт зааснаар;

⁴ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт зааснаар.

үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зургаа.Маргаан шийдвэрлэх

6.1.Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо.Гэрээний хавсралт

7.1.Хамгаалуулагч нь явах чиглэл, оролцох арга хэмжээний талаараа энэхүү гэрээний хавсралт маягтын дагуу бичгээр өгнө. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм.Бусад нөхцөл

8.1.Энэхүү гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.

8.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ;

8.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хаяг:

Хамгаалуулагч талыг төлөөлж:

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хаяг:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын тавдугаар хавсралт

БИЕЧИЛСЭН ХАМГААЛАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭ

20... оны ... дүгээр сарын ...-ны өдөр № _____ хот, аймаг

Энэхүү гэрээг нэг талаас _____ /цаашид
“хамгаалагч тал” гэх/ нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____ овогт
_____ -ын _____ /цаашид “хамгаалуулагч” гэх/ нар Монгол Улсын Иргэний
хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 6, 10, 17,
18, 20-24 дүгээр зүйл, Хууль зүйн Сайдын 2014 оны А/204 дугаар тушаалаар баталсан
“Биечилсэн хамгаалалтын журам”, _____ дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн анхан
шатны шүүхийн шүүгч

/аль тохирохыг доогуур зурах/

_____ -ны 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар тогтоол, захирамжийг тус тус

үндэслэн

/аль тохирохыг доогуур зурах/

харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, таслан зогсооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3.Хууль зүйн Сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын Хоёрдугаар зүйлийн 2.2, 2.3, 2.4, 2.5 дахь хэсэгт заасан хамгаалалтын түвшингээс хамаарч мөн журмын 2.1 дэх хэсэгт заасны дагуу тохирох хамгаалалтын арга хэмжээний хэлбэрээр хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангаж, хамгаална.

1.4.Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хамгаалуулагчийн хүсэлтээр тодорхой газар, орон зай, чиглэлд хэрэгжүүлж болно.

1.5.Хамгаалуулагчийн зөвшөөрснөөр хамгаалалтын ажиллагаанд түүний орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, харилцаа холбоог ашиглаж болно.

1.6.Тухайн өдрийн хамгаалалт дууссанаас хойш хамгаалуулагч нь гэр орон /аюулгүй газар/ болон хамгаалах байрнаас урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн гарсан, чиглэл өөрчилснөөс гадны халдлага, довтолгоонд өртсөн тохиолдолд хамгаалагч тал хариуцахгүй.

Хоёр.Хамгаалагчийн эрх, үүрэг

2.1.Хамгаалагч нь дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.Монгол Улсын хууль, дүрэм, журам, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг биелүүлэхийг хамгаалуулагчаас шаардах;

2.1.2.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээ, мэдээллийг цуглуулах, гаргуулан авах;

2.1.3.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

- 2.1.4.хамгаалуулагчаас уулзах иргэд, оролцох арга хэмжээ, бусад нөхцөл байдлыг тусгасан мэдээлэл бүхий хөдөлгөөний чиглэлийг 24 цагаас доошгүй хугацааны өмнө энэхүү гэрээний хавсралт маягтын дагуу урьдчилж авах;
- 2.1.5.урьдчилан гаргаж өгсөн хөдөлгөөний чиглэлээс бусад хөдөлгөөн үйлдэхгүй байхыг хамгаалуулагчаас шаардах;
- 2.1.6.хөдөлгөөний чиглэлийн дагуу биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд учрах эрсдэл бүхий шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд аюулгүй газарт хүргэх ажиллагааг нэн даруй зохион байгуулах;
- 2.1.7.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хамгаалуулагчийн орон байр, автомашин гадны халдлага, довтолгоонд өртсөн, өртөж болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд орон байр, автомашинд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх техник тоног төхөөрөмж суурилуулах;
- 2.1.8.энэ гэрээний 2.1.6-д заасан нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хамгаалуулагчийн ажлын байранд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулах;
- 2.1.9.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах;
- 2.1.10.хамгаалуулагчийг хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээллээр хангах;
- 2.2.Тухайн өдрийн нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх, цуцлах саналыг хамгаалуулагч талтай зөвшилцөж болно.
- 2.3.Хамгаалуулагч гадуур хөдөлгөөн үйлдэхдээ хамгаалагчид урьдчилан мэдэгдэх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд хөдөлгөөн үйлдэх асуудлыг хамгаалагч цуцалах.

Гурав.Хамгаалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хамгаалуулагч нь дараах эрх, үүрэгтэй:

- 3.1.1.хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;
- 3.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан туслалцааг авах;
- 3.1.3.хамгаалагч талд эрх, үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих;
- 3.1.4.Монгол Улсын хууль, журам, дүрэм, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг, хамгаалагч талаас өгсөн заавар, зөвлөмжтэй танилцаж, биелүүлэх;
- 3.1.5.хамгаалагч талд гэр бүл⁵, гэр бүлийн гишүүн⁶, төрөл⁷, садангийн⁸ хүн, найз нөхдийн талаарх мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
- 3.1.6.хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;
- 3.1.7.хамгаалагч талаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 3.1.8.уулзах иргэд, оролцох арга хэмжээ, бусад нөхцөл байдлыг тусгасан мэдээлэл бүхий хөдөлгөөний чиглэлийг энэхүү гэрээний хавсралтад заасан маягтын дагуу 24 цагаас доошгүй хугацааны өмнө, зайлшгүй шаардлагын улмаас хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд 3 цагийн өмнө энэхүү гэрээний хавсралт маягтын дагуу хамгаалагч талд мэдэгдэх;
- 3.1.8.хамгаалуулагч тухайн өдрийн хамгаалалт дууссанаас буюу 18 цагаас хойш гэр орон /аюулгүй газарт/ болон хамгаалах байрнаас урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн гарах, түүнчлэн урьдчилан гарган өгсөн чиглэлээс бусад хөдөлгөөн үйлдэхгүй байх;
- 3.1.9.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хамгаалах, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах;
- 3.1.10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу туслалцаа авах.

Дөрөв.Хориглох зүйл

- 4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
- 4.1.1.хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг бусдад дамжуулах, задруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх;

⁵ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2 дахь хэсэгт зааснаар;

⁶ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4 дэх хэсэгт зааснаар;

⁷ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.5 дахь хэсэгт зааснаар;

⁸ Гэр бүлийн тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт зааснаар.

- 4.1.2.хамгаалагч нь тухайн өдрийн биечилсэн хамгаалалтын арга хэмжээ бууж байгааг хамгаалуулагчид албан ёсоор мэдэгдэж, аюулгүй байдлын зөвлөмж өгч, гарын үсэг зуруулснаас бусад тохиолдолд орхиж явах;
- 4.1.3.хамгаалалтын арга хэмжээний үеэр согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх;
- 4.1.4.үзвэр, үйлчилгээ, олон нийтийн газар /зах, баар/ зорчих,олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох;
- 4.1.5.хувийн харилцаа тогтоох.

Тав.Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

- 5.1.Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үндэслэлээр хамгаалалтыг цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.
- 5.2.Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2-т заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зургаа.Маргаан шийдвэрлэх

- 6.1.Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо.Гэрээний хавсралт

- 7.1.Хамгаалуулагч нь явах чиглэл, оролцох арга хэмжээний талаараа энэхүү гэрээний хавсралт маягтын дагуу бичгээр өгнө. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм.Бусад нөхцөл

- 8.1.Энэхүү гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.
- 8.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ;
- 8.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:

Хаяг:
Утас:
Факс:
Цахим хаяг:

Хамгаалуулагч талыг төлөөлж:

Хаяг:
Утас:
Факс:
Цахим хаяг:

төсөл

20... оны дугаар сарын-ны өдөр
байгуулсан дугаар гэрээний хавсралт

ХАМГААЛУУЛАГЧИЙН ЯВАХ ЧИГЛЭЛ, ОРОЛЦОХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗАХИАЛГЫН ХУУДАС

Хамгаалуулагч _____ овогтой _____
миний бие 20... оны ... сарын ...-ны өдөр доорх цагийн хуваарь, чиглэлийн дагуу хөдөлгөөн
үйлдэж, иргэдтэй уулзаж, арга хэмжээнд оролцоно.

№	Явах чиглэл, оролцох арга хэмжээ	Хугацаа /цаг минут/

ХӨДӨЛГӨӨН ҮЙЛДЭХ ЧИГЛЭЛ,
ЦАГИЙН ХУВААРЬ ГАРГАЖ ӨГСӨН: / /

20... оны ... сарын ...-ны өдөр

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

/...../

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын зургаадугаар хавсралт

/Маягт 1/

УРЬДЧИЛАН САНУУЛАХ ХАМГААЛАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

20 ... оны ... сарын ... өдөр № хот, аймаг

..... албан тушаалтай би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай тэмдэглэл үйлдэв.

Нэг. Биеийн байцаалт:

1. /ургийн овог/ /эцэг, эхийн нэр//нэр/
2. Регистрийн дугаар:, нас:, хүйс:
3. Боловсрол:, мэргэжил:
4. Эрхэлсэн ажил:
5. Ам бүлийн байдал:
6. Оршин суух хаяг /албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг нь бичнэ./

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1. Эрүүгийн хэргийн дугаар: зүйл, хэсэг:
2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо:
3. Хэргийн товч утга:

Гурав. Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх болсон шалтгаан:

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага:

Таны 20... оны ... сарын ... өдөр хийсэн үйлдэл нь дахин давтагдвал Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн дугаар зүйлийн дэх заалтыг зөрчсөн үйлдэл гэж үзэн дээрх хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээж болзошгүй тул дахин дээрх үйлдлийг давтахгүй байхыг анхааруулан гарын үсэг зуруулав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

Гарын үсэг...../...../

/Та урьдчилан сануулах тэмдэглэлийг уншаад танилцсан ойлгосон тухайгаа өөрийн гараар бичиж гарын үсэг зурна. Хэрэв та гарын үсэг зурахаас татгалзвал татгалзах болсон үндэслэл, шалтгаанаа заавал тайлбарлан бичнэ./

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

..... /...../
/албан тушаал/ /цол, зэрэг дэв/ /гарын үсэг/ /нэр/

Тайлбар: Уг хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн тухай тэмдэглэл нь 2 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь эрүүгийн хэрэгт, 2 дахь хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

ТАНИЛЦСАН:

.....

20 ... оны ... сарын ... өдөр

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ /ӨӨРЧЛӨХ/ ТУХАЙ САНАЛ

20 ... оны ... сарын ... өдөр

№

..... хот, аймаг

..... албан тушаалтай би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20, 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.3.6 дахь хэсэг, өмгөөлөгч, прокурор, шүүгч-ны санал, гэрч, хохирогч-ны хүсэлтийг үндэслэн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх тухай саналыг-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт

1. /ургийн овог/ /эцэг, эхийн нэр/ /нэр/
2. Регистрийн дугаар:, нас:, хүйс:
3. Боловсрол:, мэргэжил:
4. Эрхэлсэн ажил:
5. Ам бүлийн байдал:
6. Оршин суух хаяг /албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг нь бичнэ./

.....
.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1. Эрүүгийн хэргийн дугаар: зүйл, хэсэг:
2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо:
3. Хэргийн товч утга:

.....

Гурав. Хамгаалалтын арга хэмжээ
хэрэгжүүлэх /өөрчлөх/ болсон шалтгаан, үндэслэл:

.....
.....
.....

САНАЛ ГАРГАСАН:

..... /албан тушаал/ /цол, зэрэг дэв/ /гарын үсэг/ /нэр/

Тайлбар: Уг хамгаалалтын арга хэмжээний санал нь 2 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 2 дахь хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

ТАНИЛЦСАН:

.....

20 ... оны ... сарын ... өдөр

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ЦУЦЛАХ ТУХАЙ САНАЛ

20 ... оны ... сарын ... өдөр

№

..... хот, аймаг

..... албан тушаалтай би Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 23 дугаар зүйлийн 23.3.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хамгаалалтын арга хэмжээг доорх үндэслэлээр цуцлах тухай саналыг-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт

- 1. /ургийн овог/ /эцэг, эхийн нэр/ /нэр/
- 2. Регистрийн дугаар:, нас:, хүйс:
- 3. Боловсрол:, мэргэжил:
- 4. Эрхэлсэн ажил:
- 5. Ам бүлийн байдал:
- 6. Оршин суух хаяг /албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг нь бичнэ./

.....
.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

- 1. Эрүүгийн хэргийн дугаар: зүйл, хэсэг:
- 2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо:
- 3. Хэргийн товч утга:

.....
.....

Гурав. Хамгаалалтын арга хэмжээг цуцлах болсон шалтгаан, үндэслэл:

.....
.....
.....

САНАЛ ГАРГАСАН:

..... /албан тушаал/ /цол, зэрэг дэв/ /гарын үсэг/ /нэр/

Тайлбар: Уг хамгаалалтын арга хэмжээг цуцлах санал нь 2 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 2 дахь хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

ТАНИЛЦСАН:

.....

20 ... оны ... сарын ... өдөр

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ ТУХАЙ САНАЛ

20 ... оны ... сарын ... өдөр № хот, аймаг

..... албан тушаалтай би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах тухай саналыг-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт

- 1. /ургийн овог/ /эцэг, эхийн нэр/ /нэр/
- 2. Регистрийн дугаар:, нас:, хүйс:
- 3. Боловсрол:, мэргэжил:
- 4. Эрхэлсэн ажил:
- 5. Ам бүлийн байдал:
- 6. Оршин суух хаяг /албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг нь бичнэ./

.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

- 1. Эрүүгийн хэргийн дугаар: зүйл, хэсэг:
- 2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо:
- 3. Хэргийн товч утга:

.....

Гурав. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах болсон шалтгаан, үндэслэл:

.....
.....
.....

САНАЛ ГАРГАСАН:

..... /албан тушаал/ /цол, зэрэг дэв/ /гарын үсэг/ /нэр/

Тайлбар: Уг санал нь 2 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 2 дахь хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

/Иргэн, албан тушаалтнаас авах нууцын баталгаа/

НУУЦЫН БАТАЛГАА

20... оны ... сарын ... өдөр № хот, аймаг

.....
/Байгууллагын нэр/
/ажил/ албан тушаалтай/
..... овогтой би

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний талаар мэдэгдсэн иргэн, албан тушаалтан бусдад энэхүү мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй” гэж заасны дагуу нууцлалыг чанд хадгалж, хамгаалахаа баталж байна.

Хэрэв би энэхүү үүргийг биелүүлээгүй эсвэл нууц задруулбал Монгол Улсын Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАСАН:

..... /овог, нэр/
..... /гарын үсэг/
..... /регистрийн дугаар/
..... /утасны дугаар/

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

..... / албан тушаал/
..... /нэр/ / гарын үсэг/

**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2014 оны “Журам батлах тухай” А/114 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД

Х.НЯМБААТАР

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ АЮУЛГҮЙ ГАЗАРТ ТҮР БАЙРЛУУЛАХ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогч /цаашид “хамгаалуулагч” гэх/-ийн амь нас, эрүүл мэнд, бие махбод, сэтгэл зүйд учирч болзошгүй заналхийлэл, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор бодит аюул арилах хүртэл хугацаанд аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг баримтлана.

1.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн хамгаалуулагчийн өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй хамгаалуулагчийг түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

1.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан байгууллагууд нь мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.10-д заасны дагуу хамгаалуулагч болон хамгаалах байрны холбогдох албан тушаалтантай хамтран ажиллах гэрээг байгуулна.

1.4.Гэрч, хохирогчийг түр байрлуулах хамгаалалтын байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байна.

1.5.Тусгай хамгаалах болон хамгаалах байр нь эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн хүмүүс байрлах тусгай өрөөнүүдтэй байна.

1.6.Тусгай хамгаалах болон хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ба зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

Хоёр.Эрсдэлийн түвшинг тодорхойлох

2.1.Хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан нь гэрч, хохирогчийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлнэ.

2.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан этгээдийг аюулгүй газарт түр байрлуулахдаа доор дурдсан эрсдлийн түвшинг харгалзан үзнэ:

2.2.1.эрсдэлийн өндөр түвшин: амь насанд нь бодитой заналхийлсэн, бие махбодид хохирол учруулсан, тарчлаасан, байнгын дарамтанд байлгасан, гэмт хэрэг үйлдэхийг тулган шаардсан, айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгисөн;

2.2.2.эрсдэлийн дунд түвшин: эд хөрөнгөнд халдсан, хамаарал бүхий этгээдэд заналхийлсэн, ятгасан, нөлөөлсөн, мөнгө, эд зүйл, албан тушаал амласан;

2.2.3.эрсдэлийн бага түвшин: хамгаалуулагчтай уулзах, харилцаа тогтоохыг оролдсон.

Гурав.Хамгаалах болон тусгай хамгаалах байр

3.1.Хамгаалах болон тусгай хамгаалах байрыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллага ажиллуулах бөгөөд хамгаалах байрыг бусад төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан ажиллуулж болно.

3.2.Хамгаалах болон тусгай хамгаалах байр нь энэ журмын 1.4 дэх хэсэгт заасан стандартын шаардлага хангасан байх бөгөөд, үйл ажиллагааны дотоод журамтай байна.

3.3.Хамгаалах болон тусгай хамгаалах байр нь тасралтгүй ажиллах, аюулгүйн нөхцөл, хамгаалалтын техник хэрэгслээр хангагдсан, хүн хүчний хүрэлцэхүйц нөөцтэй байна.

3.4.Хамгаалах болон тусгай хамгаалах байранд байрласан гэрч, хохирогчийн талаар мэдээллийн сан үүсгэж, улирал тутам Цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

3.5. Нэг гэмт хэргийн гэрч, хохирогч нарыг хамгаалах байранд хамтад нь байрлуулахыг хориглоно.

3.6.Хамгаалах байрны байршил, холбогдох бусад мэдээлэл нь нууц байх бөгөөд байрны ажилтныг тухайн ажлын байр /албан тушаал/-д томилогдсон даруйд ажил, үүргээ гүйцэтгэх хугацаанд болон тухайн ажлаас чөлөөлөгдсөн буюу өөрчлөгдсөн /халагдсан/-ий дараа хамгаалах байрны байршил, гэрч хохирогчийн талаарх мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх тухай баталгаа гаргуулан авна.

3.7.Хамгаалуулагчийн зөвшөөрснөөр түүний орон байрыг ашиглаж болно.

Дөрөв.Эрсдлийн өндөр болон дунд түвшний гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээ авах

4.1.Хамгаалуулагчийг аюулгүй газарт түр байрлуулахад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13, 21 дүгээр зүйлийн 21.2.2, 22 дугаар зүйл, энэ журмын 1.2-т заасан зөвшөөрлийг авна.

4.2.Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу зөвхөн эрсдэлийн өндөр түвшинтэй гэрч, хохирогчийг тусгай хамгаалах байранд байрлуулна.

4.3.Хамгаалуулагчийг эрх бүхий албан тушаалтны шийдвэр, эрсдлийн түвшинг харгалзан төрийн болон төрийн бус байгууллагын хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төв болон бусад хамгаалах байранд гэрээ байгуулан байрлуулж болно.

4.4.Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу хамгаалуулагчийн биед болон эд зүйлд үзлэг хийж, тэмдэглэл хөтөлнө.

4.5.Хамгаалах байранд байрлуулахад өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эд зүйлийг түр хураан авч бүртгэл хөтөлнө. Эд зүйлсийг хамгаалалтын арга хэмжээ цуцлагдаж, хамгаалах байрнаас гарах үед буцаан хүлээлгэн өгнө.

4.6.Хамгаалах байрны нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалуулагчаас нууц хадгалах баталгааг гаргуулан авна.

4.7.Хамгаалалтын арга хэмжээний явцад хамгаалуулагчийн сэтгэл зүйн сорил, аюулын эрсдлийн үнэлгээ, нөхцөл байдлыг харгалзан хамгаалах байрыг сольж болно.

Тав.Эрсдлийн бага түвшний гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

5.1.Шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрсдэлийн бага түвшний гэрч, хохирогчийг хамгаалах байранд байрлуулж болно.

Зургаа.Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах

6.1.Насанд хүрээгүй хамгаалуулагчийг асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, өмгөөлөгч, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрлөөр, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтаар байрлуулна.

6.2.Насанд хүрээгүй хамгаалуулагчийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч хамгаалах байранд хамт байх боломжгүй тохиолдолд тэдний зөвшөөрлөөр дангаар нь байлгаж болно.

6.3.Хамгаалах байрны нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор насанд хүрээгүй хамгаалуулагчид түүний хууль ёсны төлөөлөгчийг байлцуулан, нууц хадгалах талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэнэ.

6.4.Насанд хүрээгүй хамгаалуулагчийн суралцах нөхцөл боломжийг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага хангана.

6.5.Насанд хүрээгүй хамгаалуулагчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, прокурор, шүүгчийн албан бичгийг үндэслэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын зөвшөөрлөөр оролцуулах бөгөөд аюулгүй байдлыг хэрэгжүүлэгч байгууллага бүрэн хариуцна.

6.6.Энэ журмын 6.5-д заасан ажиллагаанд оролцуулах тухай албан бичгийг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч талд 24 цагаас доошгүй хугацааны өмнө хүргүүлнэ.

6.7.Энэ журмын 6.2-т заасан хамгаалуулагч нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өмгөөлөгчтэйгээ уулзах тохиолдолд хамгаалах байрнаас гадуур уулзалтыг зохион байгуулах бөгөөд энэхүү асуудлыг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага хариуцна.

Долоо.Хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа

7.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь туслалцаа үзүүлэх шаардлагыг тодорхойлон тусгай хамгаалах болон хамгаалах байранд байгаа гэрч, хохирогчид Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан туслалцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үзүүлнэ.

7.2.Энэ журмын 7.1-т заасан туслалцааг нууцлал хангасны үндсэн дээр холбогдох байгууллагатай хамтран үзүүлж болно.

7.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллагууд нь мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт заасан мэдээллээр гэрч, хохирогчийг шуурхай хангана.

Найм. Хамгаалагч болон хамгаалуулагчийн үүрэг

8.1.Нэг гэмт хэргийн гэрч, хохирогч нарыг хамгаалах байранд хамт байрлуулахгүй байх.

8.2.Хамгаалах байранд хуульд зааснаас бусад төрлийн үйл ажиллагаа явуулах, садар самуун, архи согтууруулах ундаа сурталчилах, нэвтрүүлэх, хэрэглэхгүй байх.

8.3.Хамгаалах байрны талаарх мэдээллийг задруулахгүй байх.

8.4.Хамгаалах байранд зөвшөөрөлгүй гадны хүн нэвтрүүлэхгүй, уулзуулахгүй, байх.

8.5. Хамгаалах байранд зөвшөөрөлгүй бусад уулзалтын арга хэмжээ зохион байгуулахгүй байх.

8.6.хамгаалах байрыг өөр зорилгоор ашиглах.

Ес.Бусад

9.1.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, хорих ял эдэлж байгаа хамгаалуулагчийг аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнд авахад энэ журам, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмыг баримтлана.

9.2.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---